



Соёл Эрдэм

モンゴル文化教育大学

SOYOL ERDEM UNIVERSITY



2025.04. No.71

ХЭЛТЭЙ БОЛ ДАЛАВЧТАЙ



“БИД УДАХГҮЙ ЯПОН УЛСЫГ ЗОРИНО”

モンゴル文化教育大学附属高等学校生徒訪日修学文化交流の旅

間もなく日本へ向けて出発する



Соёл Эрдэм ахлах сургууль нь жил бүр сурагчдадаа Япон орны ахлах сургуулийн үйл ажиллагаа болон ахуй соёлтой танилцуулдаг уламжлалтай билээ.

Энэ 2024-2025 оны хичээлийн жилд 25 сурагч, 2 багшийн хамт 14 хоногийн хугацаатайгаар Япон улсыг зорих гэж байна.

モンゴル文化教育大学付属高等学校では毎年、日本の高校生活や日本の文化を体験する目的で日本への修学旅行を実施している。本年度も2025年4月20日(日)から5月2日(金)までの約2週間の日程で本校生徒25名と教職員2名が日本へ向かう予定である。

本年度は駒沢女子大学及び駒沢学園女子高等学校、東京音楽大学及び東京音楽大学付属高等学校、十文字学園女子大学及び十文字女子高等学校、桜美林大学及び桜美林高等学校の学生・生徒たちと交流する予定である。

本校の生徒・教職員を受け入れてくださる学校の皆様、お世話になります。よろしくお願い申し上げます。

Соёл Эрдэм ахлах сургуулийн сурагчдын Япон улс руу зочлох аяллын хөтөлбөр (2025.04.20-2025.05.02 хүртэл 12 хоног 13 өдөр)

Сар өдөр	Агуулга	Байрлах газар
04.20 Ням гараг	05:45. Оngoцны буудалд цуглана. 07:45. Чингис хаан ОУНОБ-аас ниснэ. 13:30. Нарита онгоцны буудалд бууна. 17:00. Байрлах байр руу хөдлөнө. 18:00. Байрандаа бүртгүүлж, өрөө хуваарилах Оройн хоол Ерөнхий хариуцагч: Макихара Соичи Утас: 090-4961 - 9784 Туслах: Марина Ямаиэ Утас: 070-4068 - 3133	Хүүхэд залуучуудын Олимп цогцолбор Шибүяа дүүрэг, Камизоно чёо 3-1 Утас: 03 - 3469-2525
04.21 Даваа гараг	07:00. Өглөөний хоол Комазава охидын их сургууль, Ахлах сургуулийн сурагчидтай харилцааны арга хэмжээ Комазава охидын сургуулийн ажилтан: Яжири Казунори, Мацүшима Рин	Хүүхэд залуучуудын Олимп цогцолбор
04.22 Мягмар гараг	07:00. Өглөөний хоол Токиогийн хөгжмийн их сургууль болон Ахлах сургуулийн сурагчидтай арга хэмжээ Ахлах, их, дээд сургуулийн хамтын ажиллагааны төвийн хөгжмийн багш Хирахара Норифуми	Хүүхэд залуучуудын Олимп цогцолбор
04.23 Лхагва гараг	07:00. Өглөөний хоол Жюүмонжи Гакүэн эмэгтэйчүүдийн их сургууль, ахлах сургуулийн сурагчидтай арга хэмжээ Олон улсын солилцоог дэмжих төвийн захирал: Мацүнага Шюүи Олон улсын солилцоог дэмжих хэлтсийн дарга: Юүко Мицүно Олон улсын солилцоог дэмжих хэлтсийн ажилтан: Хоши Юүта	Хүүхэд залуучуудын Олимп цогцолбор
04.24 Пүрэв гараг	07:00. Өглөөний хоол Оберин их сургууль, Ахлах сургуулийн сурагчидтай арга хэмжээ Оберин их сургуулийн дунд, Ахлах сургуулийн захирлын Каварада Ясуфуми	Хүүхэд залуучуудын Олимп цогцолбор
04.25 Баасан гараг	10:00-12:00. Япон гэр бүлтэйгээ танилцах арга хэмжээ. (Энэ арга хэмжээ нь 160 хүний багтаамж бүхий танхимд болох ба дууссад тус бүрийн гэр бүл рүүгээ явна) Хариуцагч: Нина Казүо 03 - 5467-7041 Олон улсын харилцааны ажилтан: Нина Казүо, Такахаши, Күми	Япон гэр бүлд
04.26 Бямба гараг	Япон гэр бүлтэйгээ ярилцан, тус тусын хөтөлбөрийн дагуу явах	Япон гэр бүлд
04.29 Мягмар		
04.30 Лхагва гараг	16:00. Олимп цогцолборт цугларах Япон гэр бүлтэйгээ үздэлт, талархлаа илэрхийлэх, чөлөөт арга хэмжээ 18:00. Оройн хоол	Хүүхэд залуучуудын Олимп цогцолбор
05.01 Пүрэв гараг	Токио хотор аялах Бэлэг дурсгалын зүйл худалдан авах	Хүүхэд залуучуудын Олимп цогцолбор
05.02 Баасан гараг	08:00. Өглөөний хоол 09:30. Өрөөгөө хүлээлгэж өгөх 09:30. Галт тэргээр Нарита ОУНОБ руу 14:30. OM502 Наритагаас нисэх Чингис хаан нисэх онгоцны буудалд буух	Эх орондоо буцах

Жич: Тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан өдөр, цаг болон хөтөлбөр өөрчлөгдөж магадгүй тул анхаарна уу.

モンゴル文化教育大学付属高校生訪日修学文化交流仮日程 2025年4月20日(日)～5月2日(金) 12泊13日

日付	項目	宿泊
20日(日)	OM501 便 07:45 チンギスハーン空港発→13:30 成田空港着 到着後オリンピックセンターへ 17:00 頃チェックイン 18:00 夕食 総責任者: 牧原創一 090-4961-9784 アシスタント: 山家茉莉奈 070-4068-3133	渋谷区神園町 3-1 オリンピック記念青少年 総合センター 03-3469-2525
21日(月)	07:00 朝食 9:10 新百合ヶ丘駅到着後合流 終日: 駒沢女子大学及びその高校との交流 駒沢女子大学担当者: 矢尻和範 松島凛	同上
22日(火)	07:00 朝食 9:20 中目黒駅到着 中目黒・代官山キャンパスに到着 終日: 東京音楽大学及びその高校との交流 高大連携センター音楽科教諭: 平原憲文	同上
23日(水)	07:00 朝食 終日: 十文字学園女子大学とその高校との交流 国際交流支援センター長 松永 修一 国際交流支援課担当課長 三野 裕子 国際交流支援課 星 雄大	同上
24日(木)	07:00 朝食 終日: 桜美林大学及び高校との交流 桜美林大学中学校・高等学校校長補佐教徒 川原田康文	同上
25日(金)	10:00～12:00 ホストファミリーと対面 セ棟160人室 各ホームステイ先へ 担当者: 二名和王 03-5467-7041 国際交流担当: 二名和王 榊原江太郎	ヒッポファミリークラブ ホストファミリー
26日(土) ↑ 29日(火)	ヒッポファミリークラブ・ホストファミリー	同上
30日(水)	15:00～16:00 ホームステイ終了 (お礼の会) ホストファミリーとお別れ 自由行動 18:00 夕食	オリンピックセンター
5月1日(木)	都内見学&買物	同上
2日(金)	08:00 朝食 09:30 チェックアウト 10:00 電車で成田空港へ OM502 14:30 成田空港発→チンギスハーン航空着	帰国

注意: 諸般の事情と都合により日程内容に調整または、変更が生じる場合があります。ご了承ください。



СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ
モンゴル文化教育大学



СОЁЛ ЭРДЭМ АХЛАХ СУРГУУЛЬ
モンゴル文化教育大学附属高等学校



БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР

Гадаад хэлний орчуулагч
Програм хангамж
Олон улс, орон судлал
Аялал жуулчлал
Эдийн засаг

МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР

Гадаад хэл шинжлэл

ЗЭРГИЙН БУС СУРГАЛТ

Япон хэлний анхан, дунд шатны дамжаа
Соёл Эрдэм дээд сургуулийн CISCO академи

Япон улсын хөрөнгө оруулалттай
ЯПОН ХЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ТӨРӨЛЖСӨН АХЛАХ СУРГУУЛЬ НЬ

10 дугаар анги
11 дүгээр анги
12 дугаар ангид элсэлт авч байна.

QR код уншуулаад бүртгүүлээрэй



Магистр



Бакалавр



Ахлах сургууль



Дамжаа

ХАЯГ: СБД, 1 дүгээр хороо, Олимпын гудамж 15а

УТАС: 70118584, 89778584

Соёл Эрдэм дээд сургууль

УТАС: 70118589, 99533738

ЯПОН УЛСЫГ ЗОРИХ ГЭЖ БУЙ АХЛАХ СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН СЭТГЭГДЭЛ

修学旅行に参加する生徒たちの感想

ЯПОН ОРНЫГ 2 ДАХЬ УДААГАА ЗОРИНО



Сайн байна уу? Соёл Эрдэм ахлах сургуулийн 11А ангийн сурагч Б.Мишээл байна. Би 2 дахь удаагаа Япон орныг зорих болсондоо маш их баяртай байна. Япон хүмүүстэй танилцаж, хэлний мэдлэгээ дээшлүүлэн, шинэ мэдлэг хураах, соёлын солилцоо хийх болсондоо таатай байна. Энэ боломжийг дахин олгож байгаа сургуульдаа гүнээ талархаж байна.

皆さん、こんにちは。モンゴル文化教育大学付属高等学校2年生のミシェールです。僕は2度目に日本へ行くことを大変嬉しく思っています。日本人の方々と出会い、日本語能力を向上させ、新しい知識を獲得し、新たな文化交流ができることを楽しみにしています。改めてこのような機会を与えてくださった学校の皆様に深く感謝いたします。

ЯПОН ХЭЛЭЭР УС ЦАС ШИГ ЯРИМААР БАЙНА

Би Соёл эрдэм ахлах сургуулийн 11А ангийн сурагч Б.Мөнгөлөн байна. Тун удалгүй Япон улсыг дахин зорихоор шаргуу хичээллэж байна. Нисэх өдөр ойртох тусам сэтгэл догдолсоор.... Хоёр жилийн хугацаанд хичээн сурч буй япон хэлээ ашиглан явж байгаа хоёр дахь удаагийн аялал гайхалтай байх болов уу. Илүү олон зүйлийг үзэж танилцан, улам их туршлага хуримтлуулан, япон хэлний ярианы чадвараа дээшлүүлэнгээ Япончуудаас суралцаж өөрийгөө хөгжүүлэх маш чухал дадлага болно гэдэгт итгэлтэй байна. Энэхүү боломжийг олгож өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Макихара Соичи тэргүүтэй багш нартаа маш их талархаж байна.



はじめまして。モンゴル文化教育高等学校2年生のムングルンです。もうすぐ日本へ再び行くために勉強しています。出発の日が近づくほどドキドキしています。2年間頑張って学んだ日本語を使って行く、2度目の日本訪問が楽しみです。もっといろいろな経験をし、日本語を向上させながら、日本人の皆さんから学べる貴重な体験ができると期待しています。このような機会を与えてくださる牧原創一理事長及び先生方、ありがとうございました。

ЯПОН ОЛОН НАЙЗТАЙ БОЛМООР БАЙНА



Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би Соёл Эрдэм ахлах сургуулийн 10А ангид сурдаг. Намайг Б.Нандин гэдэг. Анх удаагаа Япон орныг зорих гэж байгаадаа туйлын баяртай байна. Япон улсад очих багын мөрөөдөл маань биелж байгаад сэтгэл өндөр байна. Япон улсын талаар илүү ихийг мэдэж олон сайхан найз нартай болно гэдэгтээ итгэл дүүрэн байна. Багш нартаа баярлалаа.

私はモンゴル文化教育大学付属高等学校の1年生のナンディンです。初めて日本に行くことができて、とても嬉しいです。日本国に訪れるといった、幼いころの夢が叶って、大満足です。日本のことをより深く知り、たくさんの友達ができることを楽しみにしています。

МӨРӨӨДЛИЙН МИНЬ НЭГ ХЭСЭГ БИЕЛЛЭЭ

Соёл Эрдэм ахлах сургуулийн 10 дугаар ангийн сурагч Өнөр овогтой Солонго байна. Би Япон улс руу явах гэж байгаадаа баяртай байна. Яагаад гэвэл надад тухайн улсын соёл, хөгжил дэвшил, аливаад хариуцлагатай ханддаг байдал, орчин гээд бүхий л зүйл ихээр таалагддаг. Надад Япон улстай өөрийн биеэр танилцах боломжийг олгосон сургуулийн хамт олон болон ээж аавдаа маш их талархаж байна. Би Япон улсад очоод олон хүмүүстэй танилцаж нэгэн дээвэр доор нэгдэж, нэг гэр бүл болж, хамгийн ихээр хүсэн мөрөөдсөн япон хүүхдүүдтэй уулзаж, тэднээс ихийг суралцан, Япон улсад суралцах хүсэл мөрөөдөл минь нэг алхам урагшилж байна гэж бодож байна.



こんにちは。高校1年生のソロンゴです。日本見学旅行に行くことが待ちきれないぐらいわくわくします。なぜなら、日本の文化・発展・環境、日本人の勤勉さなど日本のすべてがとても気に入っています。そんな日本国を実際に体験できるチャンスを与えてくれた、高校の皆さん及び両親に感謝の気持ちを伝えたいです。特に日本人の家にホームステイをして、一つの屋根の下で家族の一員として生活してみることが感動的です。ホームステイを通して、今までの夢であった日本人の子供たちと会って、彼らから色々学ぶことが将来の夢である日本留学への大きな一歩になると思っています。

ЯПОН ОЮУТНУУДТАЙ ХАМТАРСАН ДАДЛАГА ХИЙХ ХӨТӨЛБӨР

8月に桜美林大学、立教大学、常磐大学学生モンゴル環境研修が実施されます！ 日程内容

モンゴルで現地調査、視察、遊牧民生活体験（ホームステイ）、現地の学生との交流などを通じて、日本では必ずしも認知されていないモンゴルの環境問題に対して理解を深める。特に環境に配慮したソーラークッカーの普及活動やトール川の環境保護のボランティア活動を通じて途上国の環境問題に触れ、日本の経験を踏まえて持続可能な社会の構築に向けて協働する意識を身に付ける。なお、ウランバートルにおいては、JICAモンゴル事務所等を訪問し、取材することもプログラムに含まれている。研修はウランバートルにある提携校モンゴル文化教育大学の協力で行う。また同大学内に設置されている、桜美林大学ウランバートル事務所も当研修を全面的にサポートする体制をとっている。

取得単位：2単位。

2016年度から、他大学の学生及び引率教職員が参加した。

研修日程：8月9日～16日（予定）、応募資格：全学群、募集人数：10名

募集時期：2025年4月1日（火）～4月25日（金）13：00

応募手続き：e-Ryugaku上で申請

費用：約228,000円（往復飛行機代、現地での交通費、宿泊代、食事代、見学代などの諸費用を含む）

桜美林大学「短期海外研修留学奨学金制度」の対象プログラムである。

問い合わせ：引率教員：都馬 バイカル tubaikal@obirin.ac.jp

国際交流センター：留学派遣担当 outbound@obirin.ac.jp

企画：桜美林大学 基盤教育院

学内協力：桜美林大学国際センター

海外協力：モンゴル文化教育大学、桜美林大学モンゴル事務所

旅行実施：日本旅行社代理店

イーエイエス(株)

- 第1日目 8月09日（土）：成田空港で集合・出発、チンギス・ハーン国際空港に到着
- 第2日目 8月10日（日）：①オリエンテーション
②自然エネルギーの体験学習：ソーラークッカーを用いて
③モンゴル遊牧文化の実践：乗馬を体験する
④モンゴル牧畜文化の体験：屠畜
- 第3日目 8月11日（月）：①モンゴル・日本近代史：日本人墓地进行視察する
②司馬遼太郎と民間の交流：ツェベクマ記念館を見学する
③環境問題(1)：トール川沿いの都市ごみ問題を体験する
④環境問題(2)：草原退化を視察する
- 第4日目 8月12日（火）：①遊牧生活体験：遊牧民の家での1泊ホームステイ（半日）
②観光資源の見学：チンギス・ハーン像
③宗教文化の体験：シャーマニズムと儀礼視察
- 第5日目 8月13日（水）：①カラコルムへ移動
②三国記念碑
③カラコルム博物館見学
④キャンプ
- 第6日目 8月14日（木）：①ウランバートルへ移動
②モンゴル歴史学習：突厥碑
③音楽コンサート
- 第7日目 8月15日（金）：①モンゴルと日本の交流：JICA 事務所を訪問する
②遊牧文明：UNESCO 遊牧文化研究所訪問
③モンゴルと歴史と文化：チンギス・ハーン博物館
④発展する都市：ウランバートル市内を見学する
⑤現地大学生との意見交換会（レポート作成を含む）
- 第8日目 8月16日（土）：チンギス・ハーン国際空港を出発、成田空港に到着、空港で解散

注:現地の都合により、交通機関、ホテル及び日程の一部が変更されることがあります

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН НИЙГЭМД ЧИГЛЭСЭН САЙН ҮЙЛСИЙН АЯН ЖАВАР СЭНГЭСЭН ХҮЙТНИЙГ ЖАРГАЛТАЙ СЭТГЭЛЭЭР ДАВЦГААЯ!

モンゴル文化教育大学の大学生及び附属高等学校の生徒の チャリティーキャンペーン

2024 оны 12-р сарын 25-ны өдөр Соёл Эрдэм дээд сургууль, Соёл Эрдэм ахлах сургуулийн хамт олон, эрдэмтэн багш нар, оюутан сурагчид бид “Жавар сэнгэнэсэн хүйтнийг Жаргалтай сэтгэлээр давцгаая” нэрийн дор сайн үйлсийн аяны ээлжит хөтөлбөрийнхөө ӨВЛИЙН УЛИРЛЫН үйл ажиллагаагаа амжилттай зохион байгуулав.

2024年12月25日、文化教育大学と文化教育大学附属高等学校の学生、生徒、先生、教授一同が毎年恒例の「寒さ厳しき折、幸せな気持ちで乗り越えましょう！」冬のチャリティーキャンペーンを無事に実施しました。



“Жавар сэнгэнэсэн хүйтнийг жаргалтай сэтгэлээр давцгаая” сайн үйлсийн аянаар манай хамт олон халуун сүүтэй цай, илч энерги өндөр халуун чацаргана, нэрсний ундаагаар үйлчилж, олны талархал хүлээлээ.

この冬のチャリティーキャンペーンの際、大学生一同が温かいミルクティー、ビタミン豊富なサジー・ジュースと熱々としたブルーベリー・ドリンクをサービスし、たくさんの感謝の言葉を聞き、励まされました。



Манай аянд идэвхтэй оролцсон бүхий л хүмүүстээ талархсан сэтгэлээ илэрхийлье. Хөгжил хамтынх байдаг болохоор бүгдээрээ хамтдаа, улсаараа хөгжицгөөе.

私たちのキャンペーンに協力した皆様に心から感謝を申し上げます。国の発展は皆の共同体の協力によりますので、共に頑張りましょう！



СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН НИЙГЭМД ЧИГЛЭСЭН САЙН ҮЙЛСИЙН АЯН “ЭНХ УЛИРАЛ ХАНХАЛСАН ЭЭЛТЭЙ ХАВРАА УГТАЦГААЯ”

モンゴル文化教育大学の大学生や高等学校の生徒たちが、社会ボランティア活動として、家畜を寒さから守るための防寒用カバーを自ら手作りし、遊牧民に届けました。

2025 оны 3-р сарын 4-ний өдөр Соёл Эрдэм дээд сургууль, Соёл Эрдэм ахлах сургуулийн хамт олон, эрдэмтэн багш нар, оюутан сурагчид бид “Энх улирал ханхалсан ээлтэй хавраа угтацгаая” хаврын улирлын ээлжит сайн үйлсийн аянаа амжилттай зохион байгууллаа. Бид энэ удаагийн аянаа мал төллөж буй цаг үед, малчдадаа хэрэгтэй нялх төлийн элгэвч, нэмнээ, төлийн уут зэрэг малчин түмэндээ чин сэтгэлийн өргөл өргөх үйл ажиллагааг сургуулийнхаа хэмжээнд зохион байгуулсан юм.

2025年3月4日、文化教育大学と文化教育大学附属高等学校の学生、生徒、先生、教授一同が「春暖のみぎり、健やかなる春を迎えましょう！」春のチャリティーキャンペーンを無事に実施しました。私たちの今回のキャンペーンは、家畜の出産期に遊牧民の家を訪れ、子牛、子羊用の手作りコートやバッグを寄付する心を込めた企画でした。

モンゴル文化教育大学の大学生や高等学校の生徒たちが、社会ボランティア活動として、家畜を寒さから守るための防寒用カバーを自ら手作りし、遊牧民に届けました。



Бидний хандив, сэтгэлийн дэмийг хүлээн авсан Төв аймгийн Эрдэнэ сумын олон малчин, тэр дундаа зуун насыг насалж, зургаатай таягаа тулан буй Төв аймгийн Эрдэнэ сумын хамгийн өндөр настан буурайдаа эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөж байна.

私たちの寄付と本の気持ちを受け取ったトゥブ県エルデネ郡の遊牧民、特に100歳を迎える最高齢の方の健康と幸福を祈ります。



“МАНГАГИЙН ЕРТӨНЦӨӨР АЯЛСАН НЬ”

マンガの世界を巡る旅

Соёл Эрдэм ахлах сургууль дээр 2 сарын 5-25-ны хооронд “Манга” өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр сурагчид маань сургуулийн номын сангаас өөрийн унших дуртай Манга номоо уншин, Манга дүрээ цаасан дээр амиллуулж, сайхан дурсамж бүтээлээ.

Нийт сурагч маань амжилттай оролцсоноос 12а ангийн сурагч Г.Ариунзаяагийн бүтээл Тэргүүн байрт шалгарлаа. Дэд байруудад 12а ангийн сурагч Т.Төрболд, 12а ангийн сурагч Г.Баярхүү, 12а ангийн сурагч Э. Амирлин нарын бүтээл шалгаран бусдыгаа хошуучлан оролцон, өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд боллоо.

2月5日から2月25日まで文化教育高校で「マンガの日」が開催された。

この日、生徒たちは学校の図書館でお気に入りのマンガ本を読み、マンガのキャラクターを紙の上で生き生きとさせて美しい思い出を作った。参加した生徒のうち、12年生のG. アリウンザヤの作品が1位になった。12年生の T. トルボルド、の G. バヤルフー、11 年生 E. アミラリンの作品が選ばれ、それぞれに荣誉と賞金が授与されました。



ШИНЭ НОМ



モンゴル文化教育大学と日本の教育機関による国際交流の推進について

2月19日、モンゴル文化教育大学の牧原創一理事長が、桜美林大学の大槻達也理事長および畑山浩昭学長を表敬訪問し、モンゴルにおける本年度の両大学の学生同士の研修交流プログラムについて意見を交わしました。今年は、モンゴルの砂漠化生態の観察にドローンを導入する案が提案され、新たなプロジェクトとして具体的に検討を進めることとなりました。教務部長岡篤史事務室長及び国際交流センター中村文武課長にも大変お世話になりました。ありがとうございます。

また、桜美林中学校・高等学校の堂本陽子校長および川原田康文校長補佐とも面会し、本学附属高等学校の訪日修学旅行の際に、両高等学校の生徒による文化交流が実現することとなりました。

さらに、日本私立大学協会の小出秀文局長および坂下景子様の多大なるご支援・ご尽力により、東京音楽大学・高大連携センターならびに十文字学園高等学校との文化国際交流が実施される運びとなりました。この場をお借りして、心より感謝申し上げます。そして、東京音楽大学および十文字女子大学の学長をはじめ、諸関係者の皆様にも深く御礼申し上げます。

加えて、学校法人駒沢学園の葛城天快理事長、臼井実穂子学長をはじめ、教育研究推進センターの矢尻様を含む関係者の皆様より、多大なるご支援・ご協力を賜りましたことに、心より感謝申し上げます。

今回のモンゴルと日本の高校生および大学生による国際文化交流の実現に向け、ご尽力いただいたすべての関係者の皆様に、改めて深く感謝申し上げます。誠にありがとうございました。

БИД ХУУЛИА ДЭЭДЭЛЖ, ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛДЭГ

Монгол Улсын Засгийн газрын “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх” журамд заасны дагуу улс орон даяар зарлан мэдээлэх, дохиогоор дадлага, сургуулилт хийх үйл ажиллагаа 2025 оны 3-р сарын 27-ны өдрийн 16,00 цагт болов. Соёл Эрдэм дээд сургууль, Соёл Эрдэм ахлах сургуулийн багш ажилтан, оюутан, сурагчид бид эл үүргийг ухамсартайгаар хүлээн авч, гамшгаас хамгаалах дадлага сургуулилтаа амжилттай гүйцэтгэв. Энэ өдрийн хичээл сургалтын үйл ажиллагааны цагаар болзошгүй гамшгаас сэргийлэх, тэр тусмаа хаврын хуурайшилттай энэ үед галын аюул гаргахгүй байх, зам тээврийн осол аюул эндлээс болгоомжлох, эрсдэлийн үед өөрийгөө болон найз нөхөд олон нийтийг хамгаалах, анхны тусламж тусалцаа үзүүлэх болон сургуулийнхаа аюулгүй байдлын зураг, гарцыг таниулж, галын хор зэрэг багаж техник хэрэгслийг шаардлага гарсан үед хэрхэн зөв ашиглах, ямар арга хэмжээ авах зэрэг талаар сэрэмжлүүлэг таниулга хийлээ.



私たちは法律を厳守し、役割を果たす

2025年3月27日の午後4時、モンゴル政府の「災害警報」規定に従い、全国的な警報信号訓練が実施されました。モンゴル文化教育大学とモンゴル文化教育大学附属高校の教職員、学生や生徒、先生と教師らがこの役割を果たし、警報信号訓練を無事に実施しました。同訓練では、起こりうる災害の予防方法、特に乾燥する春の季節に火災の危険を避ける方法、交通事故を防ぐ注意事項、危険なときに自分自身や友達、そして公衆を守る方法、応急処置のテクニック、学校の安全マップと出口を案内する方法、必要に応じて消火器やその他の機器の適切な使用方法や取るべき対策に関する講義が行われました。

モンゴルは比較的平和で落ち着いているが、愛国心のある国民として自分自身や他人を起こりうる危険や災害から守れる能力は現代の不可欠な必要性である。そのため、本校は社会的責任の一環としてこの全国的な対策に常に注意を払っており、今回も政府、すなわち総合緊急事態管理庁による指示を無事に遂行することができました。

法律を厳守し、国民の役割を果たし、責任を負うことはモンゴル文化教育大学や高校の学生と生徒、教職員一同の常に従う義務の一つでもあります。



РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Үүсгэн байгуулагч: Соёл Эрдэм дээд сургууль

МАНАЙ ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо,
Олимпийн гудамж Соёл Эрдэм сургуулийн байр
Шуудангийн хайрцаг 48/88
info@soyolderdem.edu.mn
news@soyolderdem.edu.mn


Шуудангийн хайрцаг: P.O.Box 44-88 Ulaanbaatar.MONGOLIA
Утас: 70116947, 70118588, 70118584
Утас: 11-328584, 11-326947

Вэб хуудас: www.soyolderdem.edu.mn
“Чөлөөт хэвлэл сан” хэвлэх үйлдвэрт хэвлэв.

桜美林大学との文化交流

2月19日、弊学の牧原理事長が桜美林大学の小槻理事長・畑山学長を表敬訪問し、両大学の文化交流や、今年度に桜美林大学の学生が予定しているモンゴル環境研修について意見交換を行いました。今回の訪問では、学生交流や研修プログラムを通じて、学術面のみならず文化面においても連携を深め、より充実した国際交流・協力体制を築くための協議が中心となりました。

また、桜美林中学校・高等学校の堂本陽子校長、川原田康文校長補佐とも面会し、4月に予定されている弊大学附属高等学校の訪日修学旅行の際、桜美林中学校・高等学校と行う文化交流について打合せを行いました。



САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН БОЛЛОО 学生スポーツ大会が開催された

Соёл Эрдэм дээд сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилийн Спорт өдөрлөг 2025 оны 2-р сарын 8-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Сагсан бөмбөгийн тэмцээний

Тэргүүн байр:	Гадаад хэл орчуулга 3Б анги
Дэд байр:	Программ хангамж 3Е анги
Гутгаар байр:	Гадаад хэл орчуулга 4Б анги

Гар бөмбөгийн төрөлд

Тэргүүн байр:	Гадаад хэл орчуулга 3Б анги
Дэд байр:	Гадаад хэл орчуулга 4Б анги шалгарч медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа.

モンゴル文化教育大学の2024～2025年度のスポーツ大会が2025年2月8日に無事に実施されました。

バスケットボール大会の1位： 日本語通訳翻訳学科3年生
2位：コンピューター・ソフトウェア学科3年生
3位：日本語通訳翻訳学科4年生

バレーボール大会の1位： 日本語通訳翻訳学科3年生
2位：日本語通訳翻訳学科4年生がそれぞれメダル、表彰状及び報酬を受賞した



СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД БОЛОН АХЛАХ СУРГУУЛИЙН БАГШ, АЖИЛЧИД ЯПОН ОРНООР АЯЛЛАА

モンゴル文化教育大学教職員の訪日文化交流の旅

ОЛОН ЗҮЙЛИЙГ ҮЗЭЖ ХАРЖ МЭДЭРСЭН
САЙХАН АЯЛАЛ БАЙЛАА

ӨӨР ЕРТӨНЦӨД ОЧСОН МЭТ МЭДРЭМЖ
ТӨРҮҮЛСЭН

Би 2025 оны 1-р сарын 10-аас 17-ны өдрийн хооронд ажлын хамт олонтойгоо Япон улсад аялаад ирлээ. Бидний аялал сонирхолтой адал явдалтай маш олон зүйлийг үзэж харж мэдэрсэн сайхан аялал амралт байсан. Япон улсын хөгжил цэцэглэлт соёл ёс заншил аялал жуулчлалын таатай байдал гээд олон зүйлийг үзэж харлаа. Япон улс нь халуун рашаанаараа дэлхийд алдартай билээ. Халуун рашаанд орж, үнэхээр тааламжтай сайхан амарсан.

Мөн хоол нь Монголын хоолтой төстэй, зөөлөн сайхан амттай байсан гэх мэтчилэн дурсаад байвал олон зүйл байна. Тус улсын ХҮНЭЭ гэсэн бодлого үнэхээр сайхан санагдсан. Энэ завшааныг ашиглаад сайхан аялал зохион байгуулж, аялах боломж олгосон Соёлт багшдаа баярлалаа. Ажилд нь амжилт хүсье.



2025年1月10日から1月17日に仕事仲間となる先生方と一緒に日本へ旅行しました。今回の観光は素晴らしく、興味深く、冒険的でした旅行と冬休みとなりました。

日本の発展、文化、習慣、観光の便利さなど、様々なことを経験しました。日本の温泉は世界的に有名であり、温泉に入ってリラックスしたのは本当に気持ち良かったです。

日本食は柔らかくて美味しく、モンゴル料理に似ていた事など長点が沢山ありました。また、日本の国民を優先とする政策は本当に素晴らしく羨ましく思いました。この場を借り、私たちの旅行を企画してくださった牧原理事長に感謝を申し上げ、幸福をお祈りします。

Нарлаг Япон орноор 1 сарын 10-17-ны хооронд аялсан аялал амжилттай болж, үзэсгэлэнтэй Фүжи уул, хэзээ ч мартагдашгүй гайхамшигт Токио Скай цамхаг, сэтгэл хөдөлгөм Асакусa сүмийн Сэнсожа дуган, дэлхийн алдарт хамгийн олон хүн нэг зэрэг зөрөн өнгөрөх гарц, Такэшито гудамжны өндөр барилгууд, цэвэрхэн, олон өнгөөр алагласан, дэлхийд алдартай брэнд дэлгүүрүүдээр худалдаа хийж, үндэснийх нь хоолыг зооглон, явсан мөч бүхэлдээ өөр ертөнцөд очсон мэт мэдрэмж төрүүлсэн нь миний амьдралын нэгэн дурсамж байлаа.

Япон орныг таньж мэдэх аяллыг зохион байгуулж, сэтгэл зүрхээрээ туслан, тав тухтай үйлчилсэн захирал Макихара Соичи, гадаад харилцааны ажилтан Б.Хашчулуун болон бусад хамт олондоо маш их баярлалаа.

1月10日から1月17日まで、「日の丸」の国である日本への旅行は無事に実施されました。

美しい富士山、いつまでも忘れられない素晴らしい東京スカイツリー、感動的な浅草の浅草寺、世界で最も有名な東京スクランブル交差点、竹下通りの高層ビル、清潔でカラフルな世界的に有名なブランド店、そして各国の料理を食べる瞬間は、まるで別の世界にいるような気分でした。今回の旅行は私の人生で忘れられない思い出となりました。

この快適な旅行を企画し、様々な面で心を込めてサポートしてくださった牧原理事長と国際交流部のハンチョローンさん及び一緒に旅行した先生方々に感謝を申し上げます。



ЯПОН ХЭЛНИЙ ТҮВШИН ТОГТООХ ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН СУРАГЧДАДАА БАЯР ХҮРГЭЭ

多くの生徒が日本語能力試験に合格しました。おめでとうございます！

Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT)-д манай сурагчид амжилттай оролцлоо. Бид энэ шалгалтынхаа хариуг албан ёсоор хүлээн авсандаа баяртай байна. Хариуг танилцуулбал: N3 түвшинд 1 сурагч, N4 түвшинд 5 сурагч, N5 түвшинд 1 сурагч тэнцсэн амжилт гаргалаа. 3 сарын хугацаа богинохон хэдий ч, сурагчдын маань хичээл зүтгэлийн үр дүн гарсаар байгаад манай нийт хамт олон баяртай байна.

Тэнцсэн сурагчдадаа халуун баяр хүргэе!

1. Б.Мөнхтүвшин	/12a анги/	N3 түвшин
2. Э.Амирлан	/11a анги/	N4 түвшин
3. Н.Амирлан	/11a анги/	N4 түвшин
4. С.Дөлгөөн	/11a анги/	N4 түвшин
5. Т.Оюунбилэг	/11a анги/	N4 түвшин
6. У.Хүслэн	/11a анги/	N4 түвшин
7. Б.Энэрэл	/11a анги/	N5 түвшин

JLPT日本語能力試験結果発表
日本語能力試験の結果が通知された。2024年12月に実施されたJLPTの結果を発表します！ N3合格者1名、N4合格者5名、N5合格者1名でした。3ヶ月という短期間でしたが、生徒たちの努力が身を結ぶ結果となりました。
合格した皆さん、おめでとうございます！
1. ムンフトゥブシン N3レベル合格 /高校3年生/
2. E. アミルラン N4レベル合格 /高校2年生/
3. N. アミルラン N4レベル合格 /高校2年生/
4. ドウルグーンN4レベル合格 /高校2年生/
5. オユンビレグN4レベル合格 /高校2年生/
6. フセレン N4レベル合格 /高校2年生/
7. エネレル N5レベル合格 /高校2年生/



Япон улсын япон хэлний түвшин тогтоох шалгалтад тэнцсэн Соёл Эрдэм ахлах сургуулийн сурагчид
日本語能力試験に合格した高校生たち 12月15日

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ –III БОТЬ (2025 №1) ХЭВЛЭГДЭВ

モンゴル文化教育大学学術論文集 第3巻が出版

Соёл Эрдэм дээд сургуулийн үйл ажиллагааны гол чиглэлийн нэг нь эрдэм судлал билээ. Тэр тусмаа, Монгол дахь Япон судлал хийгээд Монгол хэл шинжлэл, Орчуулга зүй, Монгол утга зохиол судлал, Соёл судлалын чиглэлээр ахисан түвшинд судалгаа хийж буй бидний үйл ажиллагааны нэгэн үр дүн - СЭДС-ийн Эрдэм шинжилгээний бичиг–III боть (2025 №1) 2025 оны 2-р сарын 27-ны өдөр хэвлэгдэн нийтийн хүртээл боллоо.
СЭДС-ийн Эрдэм шинжилгээний бичиг–III боть (2025 №1)-д СЭДС-аас 2024 оны 8-р сарын 4-нд Япон улсын Элчин сайдын яам болон Японы Обирин их сургуультай хамтран зохион байгуулсан “Монгол-Японы эрт, эдүгээ, ирээдүй” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний ээлжит VII бага хурлаар хэлэлцүүлсэн эрдэмтэн судлаачдын илтгэлүүд орсон болно.
Тус хуралд Япон улсаас суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Игавахара Масарү, Оберин их сургуулийн захирал, профессор Хатаяма Хироаки нар хүрэлцэн ирж оролцсоныг онцлон тэмдэглэж байна.

モンゴル文化教育大学の主な活動分野の一つは研究であります。特に、日本研究、モンゴル語学、翻訳研究、モンゴル文学研究、モンゴル文化研究分野において先進的な研究を行う我々の活動成果の一つが『モンゴル文化教育大学学術論文集-第3巻』の出版となり、2025年2月27日に一般公開されました。
学術論文集第3巻には、2024年8月4日に、モンゴル文化教育大学主催、在モンゴル日本大使館と日本の桜美林大学共催の「モンゴルと日本の過去、現在、未来」に関する定期的な国際学術会議で議論した学者らの論文が記載されています。
特筆すべきは、この学術会議に井川原賢在モンゴル日本国特命全権大使と畑山浩昭桜美林大学学長が出席しました。

Мөн ботид Хэл шинжлэл, Утга зохиол судлал, Орчуулга зүй, Соёл судлалын чиглэлээр эрдэмтэн судлаачдын сүүлийн үед бичсэн, тухайлбал Монгол Улсын Ардын багш, доктор, профессор Л.Дашнямын “Монгол мал-Залуучуудын анхааралд”, Оберин их сургуулийн профессор Хори Киёошийн “Эдийн засгийн хөгжил болон жижиг дунд үйлдвэрлэл -энтрепренерүүдийн гүйцэтгэх үүрэг”, Оберин их сургуулийн профессор Тозаки Хажимэгийн “Аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг дэмжих зорилгоор Монгол, Японы хамтын ажиллагааг эрчимжүүлэх тухай” Соёл Эрдэм дээд сургуулийн Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөлийн гишүүн, доктор, профессор Ж.Баатарцогтын “Монгол, Японы хоорондын соёлын харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх асуудал”, Оросын Холбооны Улсын Шинжлэх ухаан академийн Сибирийн салбарын Монгол, Төвөд, Будда судлалын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбарын эрхлэгч доктор, профессор Е.В.Сундуевагийн “Монгол хэлний “Хужир” гэдэг утгатай дэвсгэр газрын нэрс”, Өвөр Монголын Багшийн их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн багш доктор Бо Минагийн “Монгол зуучлуурын хэлэн дэх Англи зээллэг үгийн хэрэглээний байдал (zasag.mn сайтын жишээн дээр), Оберин их сургуулийн профессор Тоба Байкаругийн “Ийм хэмээн миний сонссон нь”, Өвөр Монголын Багшийн их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн докторант Тэргэлийн “Нобелын шагналт зохиолч Анни Эрногийн “Урт удааны сар” романы шинэчлэлт чанар”, Монгол Улсын Их Сургуулийн докторант Сарантуяагийн “Монгол түүхэн зохиолд соёлын биет бус өвийг дүрслэн хадгалж, дамжуулан өвлүүлж ирсэн уламжлал, туршлага”, Японы Велнесс эрүүл мэнд, спортын их сургуулийн багш, доктор, профессор Томикава Рикидугийн “Монгол бөхийн цолын түүх уламжлал болон зангианы тухай товч өгүүлэх нь”, Соёл Эрдэм дээд сургуулийн багш, магистр Асами Коичирогийн “Б.Явуухулангийн орчуулсан Хайкугийн Англи-Орос хэлний орчуулгын харьцуулал” тэргүүт 20 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгдсэн байна.



今回の学術論文集には、言語学、文学研究、翻訳研究、文化研究の学者による最近の著作が記載されています。特に、L. ダシニャム・モンゴル人民教師、博士教授の「モンゴルの家畜 - 若者の間に」、桜美林大学堀潔教授の「経済発展と中小企業における起業家の役割」、桜美林大学戸崎 肇教授の「観光開発政策を支援するためのモンゴルと日本の協力強化について」、モンゴル文化教育大学取締役役員J. パータルツォグト教授の「モンゴルと日本の文化交流の深化について」、ロシア科学アカデミーシベリア支部言語学部門長E. V. スンドゥエフ博士の「「フジル」を意味するモンゴルの地名」、中国内モンゴル師範大学モンゴル学研究科教授ボ・ミナギ博士の「モンゴル中間言語における英語借用語の使用」（出典：zasag.mn）、トバ・バイカル桜美林大学教授の「私が聞いた話」、テルゲル中国内モンゴル師範大学モンゴル学研究科学生の「ノーベル賞作家アニー・エルノの小説『ロング・ムーン』の革新的な性質について」、サラントヤ・モンゴル国立大学研究科学生の「モンゴルの歴史書には、何世代にもわたる無形文化遺産の受け継がれた伝統と保存経験」、富川力道日本ウエルネス・スポーツ大学教授の「モンゴル力士のタイトル（階級）の歴史と伝統及びつながりについて」、モンゴル文化教育大学の浅海宏一郎の「B. ヤヴウフラン訳俳句の英露訳の比較」を含む 20 件の論文が出版されています。

ЯПОН УЛСЫН КОМАЗАВА ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛААР ҮСҮИ МИНЭКО БАГШ ТОМИЛОГДСОНД БАЯР ХҮРГЭЕ

弊学と駒沢女子大学との文化交流にご尽力された臼井実稲子教授が 駒沢女子大学の学長に就任されました。おめでとうございます！

Соёл Эрдэм дээд сургууль нь Япон улсын их дээд сургуулиудтай гадаад харилцааны хүрээнд хамтран ажилласаар ирсэн. Ийнхүү 2024.09.02-нд Япон улсын Комазава охидын их сургуультай хамтран ажиллах талаар санал солилцож уулзалт хийсэн билээ. Ийнхүү 2024 оны 10 дугаар сард хамтран ажиллах гэрээг байгуулсан. Хамын ажиллагааны хүрээнд багш, оюутан солилцооны хөтөлбөр мөн хамтарсан дадлага зохион байгуулах гэх мэт ажлуудыг хамтран хэрэгжүүлнэ.

Япон улсын Комазава их сургуулийн Захиралаар Үсүи Минэко багш томилогдсон байна. Захирал багш Үсүи Минэкод ажлын амжилт хүсье.

Соёл Эрдэм дээд сургуулийн хамт олноос.

モンゴル文化教育大学は日本の大学と交流を続けている。2024年9月2日に駒沢女子大学の学生・教職員が本学を訪問し、本学の学生らと交流した。2024年10月には学術交流協定を締結した。この協定には交換留学プログラムやインターンシッププログラム等が含まれている。

このたび、駒沢女子大学との文化交流に多大なるご尽力を賜りました臼井実稲子教授が、同大学の学長にご就任されましたことを心よりお祝い申し上げます。

参照
新学長就任のお知らせ | ニュース&トピックス | 新着情報 | 駒沢女子大学・駒沢女子短期大学



ЯПОН УЛСЫН ВВИ БАЙГУУЛЛАГЫН ШУГАМААР ИРСЭН ЯПОН ХЭЛНИЙ БАГШ ЁШИОКА СООШИГИЙН СЭТГЭГДЭЛ

VBI日本語教師海外派遣プログラムに参加した吉岡草志先生の感想

Намайг Ёшиока Сооши гэдэг. Би Нийгатад төрсөн бөгөөд 19 нас хүртлээ Нийгатад байсан. Манай Нийгатад цас их ордог, далай, гол горхи ихтэй болохоор загас ихтэй. Бас цагаан будаа сайн ургадаг. Харин одоо би Шига мужид амьдарч байна. Учир нь миний сурдаг сургууль Шигад байдаг юм. Шигад далай байхгүй ч гэсэн Бива гэдэг том нуур байдаг. Шига дэд бүтэц сайтай, амьдрахад тохиромжтой газар юм.

Би багаасаа аваад өнөөг хүртэл тасралтгүй дугуйланд явж байгаа ба их сургуулийн оюутан болоод ганцаарчилсан дугуйлангийн багшаар 2 жил ажилласан. Тэгээд энэ туршлагаа, ашиглах, хэрэглэх, хуваалцах зорилгоор Япон хэлний багшийн дадлага ажил хийж үзэхээр Монголд ирсэн юм. Ингээд би Монголд ирээд 3 долоо хоног болж байна. Би яагаад Япон хэлний багш болъё гэж бодсон бэ гэвэл, өнөө үед японы нийгэмд төрөлт багасаж, хүн амын тоо буурч цаашид магадгүй гадаад улсаас ажилтан авах хэрэгцээ нэмэгдэж магадгүйг бодолцсон юм. Тийм учраас би Япон хэлний багш болохоор шийдэж VBI-ийн шугамаар Соёл Эрдэм дээд сургуульд япон хэлний багшаар ирээд 3 долоо



хоног болж байна.

Миний хувьд Монгол улсын талаар “сумо”, “малчин хүмүүс” гэсэн төсөөлөлтэй байсан. Харин судлаад үзтэл Монгол Улс нь саяхан болтол социалист дэглэмтэй улс орон байжээ. Улсын нийслэл Улаанбаатар хот нь өндөр хөгжилтэй хэдий ч хөгжиж буй хот гэдгийг мэдэж авсан юм. Япон, Монгол хоёр ойрхон ч гэсэн асар их ялгаатай байдал нь миний сэтгэлийг татаж, Монголыг зорих хүсэл төрсөн юм.

Соёл Эрдэм дээд сургуульд ирээд анх бодитоор хичээл заахад сандарч байсан ч, оюутнуудтай

ярилцаж үзтэл харилцан ойлголцож хөгжилтэй байж чадсан. Би яг үнэндээ Япон хэлний дүрэм гэх мэт бусад багш нарын заадаг хичээлийг зааж чадаагүй байж магадгүй ч гэсэн, Японы соёл, Япон хэлний яриаг практикт хэрхэн ашиглах зэрэг “бусад чухал зүйлсийг” зааж чадсан гэж өөртөө итгэлтэй байна. Соёл Эрдэм дээд сургуулийн хамт олонд баярлалаа. Мөн Соёл Эрдэм дээд сургуульд ажиллаж байгаа манай япон багш Асами ахдаа маш их баярласан шүү.

Япон улсын VBI байгууллагын шугамаар ирсэн Япон хэлний багш Ёшиока Сооши

約三週間お世話になりました。吉岡草志です。私は新潟で生まれて、現在は通っている大学のある滋賀県で暮らしています。新潟は19年いたためよく知っており、雪が降り海に面していて川も多いため米がおいしくて魚がよく取れる土地です。今住んでいる滋賀は海がなく大きい湖の琵琶湖に面していて、交通の便もよくとても住みやすい土地です。

これまで私は小学生から大学に入るまでずっと塾に通わせてもらったことから、大学生になってから個別指導の塾で約2年間働かせてもらいました。その経験を活かしたことをできないかと思い、日本語

教師のインターンをやってみたいと考えました。加えて日本は少子高齢化と人口減少により、今後外国人労働者の需要が増える。そうすると日本語教師の需要も増えるのではないかと考えて、日本語教師をやってみたいと考えました。

モンゴルという国は相撲の力士と遊牧民のイメージが強かったのですが、調べていくうちに最近まで社会主義国であったり、ウランバートルはとても発展しているが発展途上国であったり、日本と近くにありながら日本との相違点が多いことに魅力を感じてモンゴルという国を選びました。

実際に大学で働いてみると最初は緊張しましたが、話していくうちに生徒と打ち解けることができ、生徒に楽しんでもらいながら、日本語を教えることができました。正直僕には日本語の文法など他の先生方が教えていることは教えられなかったですが、日本の文化や日本語の実践的な使い方など“その他大事なこと”を教えられたのではないかと思います。

最後になりましたが、モンゴル文化教育大学と高校でお世話になった先生生徒の皆さん本当にありがとうございました。

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ГАДААД ХЭЛНИЙ ОРЧУУЛГА ХӨТӨЛБӨРИЙН 2-Р КУРСИЙН ОЮУТАН Б.БАЯНБИЛЭГИЙН ТОКИВА ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦСАН СЭТГЭГДЭЛ

常磐大学交換留学プログラムに参加した日本語通訳翻訳学科2年生B.バヤンビレグの感想

2024 оны 9 дүгээр сарын 10- 2025 оны 2 сарын 27-ныг хүртэл Япон улсын Ибараки мужийн Мито хотын Токива их сургуульд “Оюутан солилцооны хөтөлбөр”-ийн 2-р ээлжийн тэтгэлэгтэйгээр бүтэн улирал суралцаад ирлээ. Оюутан Б.Баянбилэг миний бие анх уг хөтөлбөрийн тухай сонсоод, ихэд сонирхож, ярилцлагад бүртгүүлэн, шалгаруулалтад оролцож тэнцээд маш их баяртай байсан. Төд удалгүй би Япон орныг зорин очиж, сургуульдаа очоод, Токива сургуулийн оюутны дотуур байранд амьдарч эхэлсэн. Энэ үед надад танихгүй газар, мэдэхгүй зүйл олон байсан боловч, суралцаж байсан сургуулийн маань ажилчид болон дотуур байранд цуг байрлаж байсан япон оюутнууд надад туслан, олон зүйл дээр дэмжлэг болж байсанд, би маш их талархдаг. Суралцах үед надад тулгарч

байсан гол асуудал нь ярилцах буюу яриа байсан. Гэсэн хэдий ч би өдөр болгон өөртөө сануулж, шаардлага тавьж, “Одоо л биш бол хэзээ ч үгүй” гэсэн үгийг ямагт өөртөө хэлж, япон хүмүүстэй харилцан ярьж, өдөр бүрийнхээ хичээлд шамдан хичээж байсан билээ. Хэдий бага хугацаа биш ч гэсэн би өөрийгөө ойлгуулж чадахгүй 2 сар орчим болсон. Тэгсэн ч үл шантран хичээсний үр дүнд 3 дахь сар болоход, сая нэг Японоор чөлөөтэй ярьж эхэлсэн. Тухайн үеэс би, бусад улсаас ирсэн, надтай ижил оюутнуудтай дотносон нөхөрлөж, харилцан сайн найзууд болж, хичээл номоо ойлгон, үлдсэн хугацаанд маш зугаатай бөгөөд их зүйл сурсан үнэ цэнтэй өдрүүд үргэлжилсэн юм. Бүтэн 6 сар гэхэд урт санагдаж болох ч, маш хурдан өнгөрсөн сайхан өдрүүд байлаа.



私は2024年9月10日から2025年2月27日まで、茨城県水戸市にある常磐大学で、2期目の奨学金を受けて、交換留学プログラムに参加しました。

このプログラムのことを初めて聞いたとき、とても興味を持ち、すぐに応募しました。そして、合格したときは本当に嬉しかったです。しばらくして日本へ渡り、大学の寮での生活を始めました。最初は知らない場所や分からないことが多く、不安もありました。しかし、大学の職員の方々や、一緒に寮に住んでいた日本人学生が、たくさん助けてくれて、本当に感謝しています。

留学中、私が最も苦労したのは会話でした。でも、「今やらなければ、いつで

きるのか」と自分に言い聞かせ、毎日努力しました。日本人と積極的に会話し、授業にも一生懸命取り組みました。それでも、自分の考えをうまく伝えられず、約2ヶ月間はおどかしい思いをしました。しかし、努力の結果、3ヶ月目にはようやく日本語をスムーズに話せるようになりました。

その頃から、他の国から来た留学生とも仲良くなり、良い友人関係を築くことができました。授業の内容も理解できるようになり、残りの留学期間はとても楽しく、学びの多い、貴重な時間となりました。6ヶ月間は長いようで、あっという間に過ぎてしまいました。皆さんありがとうございました。

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ, СОЁЛ ЭРДЭМ АХЛАХ СУРГУУЛИЙН БАГШ, АЖИЛТНУУД ЯПОН ОРНООР АЯЛЛАА モンゴル文化教育大学、附属高等学校教職員訪日旅行記念写真

モンゴル文化教育大学及び附属高等学校の教職員が冬休みを利用し、2025年1月に訪日文化交流の旅を実施しました。

今回の訪問では、富士山、浅草、東京都庁、新宿の夜景など、日本の代表的な観光名所を巡りました。また、ハワイアンズやスパジャポーなどの温泉施設も訪れ、日本の温泉文化を存分に楽しみました。参加者からは「とても楽しかったです。美しい思い出になりました」との声が多く寄せられ、大いに喜ばれていました。



最新ニュース



3月17日、東京にて、右から順に元JAL社長の中野様、ベストワールド(株)代表取締役の八尾修生様、日本私立大学協会事務局長の小出秀文先生、そして牧原理事長らが、モンゴルとの交流に関する面談を行いました。なお、日本私立大学協会のご支援とご推薦により、弊学の高校生が訪日修学旅行で日本の大学や高等学校と交流を実現することができました。この場を借りて、心より感謝申し上げます。



3月21日、アマルバヤル・アリオナーさんの東京大学大学院修了を記念して、ヒッポファミリークラブの主催により、横浜市戸塚区民文化センターでアマルバヤルファミリーコンサートが盛大に開催されました。また、子どもたちによる「スーホの白い馬」の朗読も披露され、大きな拍手が送られました。



モンゴル文化教育大学&付属高校の教職員が旧正月を祝って
3月5日



大学生の吉岡草志さん(21歳)は、BBJ日本語教師海外派遣プログラムにより弊学へ紹介され、約1か月間の日本語教師インターンシップに参加されました。ちょうどモンゴルの旧正月にあたり、大草原で新年のご挨拶の年始回りを体験したり、乗馬を楽しんだり、貴重な文化交流の機会に恵まれました。おかげさまで、非常に収穫の多い実習となったと言えます。



手前はムンフバヤル教授



手前は100歳のデジドおばあちゃん



モンゴル文化教育大学の大学生や高等学校の生徒たちが、社会ボランティア活動として、家畜を寒さから守るための防寒用カバーを自ら手作りし、遊牧民に届けました。